



МОНГОЛ УЛС ШАДАР САЙДЫН ТУШААЛ

20 20 оны 11 дугаар
сарын 20 -ны өдөр

Дугаар 142

Улаанбаатар
хот

Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед хүнс, нэн шаардлагатай бараа бүтээгдэхүүний тээвэрлэлт, түгээлтийг зохицуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1, 28.1.5, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 178, 181 дүгээр тогтоол, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 01/5452 дугаар албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед хүнс, нэн шаардлагатай бараа бүтээгдэхүүний тээвэрлэлт, түгээлтэд шуурхай зохицуулалт хийх штабын бүрэлдэхүүн"-ийг нэгдүгээр хавсралтаар, "Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед хүнс болон нэн шаардлагатай бараа бүтээгдэхүүнийг тээвэрлэх, түгээхэд баримтлах түр журам"-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хүнсний болон нэн шаардлагатай бараа бүтээгдэхүүний тээвэрлэлт, түгээлтийг "Тээврийн удирдлагын нэгдсэн систем"-ийг ашиглан зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга, "Автотээврийн үндэсний төв" Төрийн өмчит үйлдвэрийн газарт тус тус үүрэг болгосугай.

3. Хүнс болон нэн шаардлагатай бараа бүтээгдэхүүний тээвэрлэлт, түгээлтийг тээврийн удирдлагын нэгдсэн системийг ашиглан зохион байгуулах боломжийг бүрдүүлж, найдвартай ажиллагааг хангах, шаардлагатай мэдээллийг хэрэглэгчдэд шуурхай хүргэж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд /Л.Халтар/-д үүрэг болгосугай.

4. Хүнс болон нэн шаардлагатай бараа бүтээгдэхүүний нийлүүлэлт, тээвэрлэлт, түгээлтийг Улаанбаатар импекс гаалийн хяналтын бүс болон бусад томоохон агуулах, ачааны терминалаар дамжуулан нэгдсэн байдлаар зохион байгуулахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Гаалийн ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.

0010571

5. Энэ тушаалын хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд /Л.Халтар/, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд /З.Мэндсайхан/, дэмжлэг үзүүлэн хамтран ажиллахыг Цагдаагийн ерөнхий газар /Ж.Болд/, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар /Т.Гантулга/, Онцгой байдлын ерөнхий газрын дарга /бригадын генерал Г.Ариунбуян/ нарт тус тус даалгасугай.

Монгол Улсын Шадар сайд



Я.СОДБААТАР



Монгол Улсын Шадар сайдын
2020 оны 42 дугаар тушаалын
нэгдүгээр хэсрэлт

Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед
хүнс болон нэн шаардлагатай бараа бүтээгдэхүүний тээвэрлэлт,
түгээлтэд шуурхай зохицуулалт хийх штабын бүрэлдэхүүн

Шуурхай штабын дарга	Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд
Гишүүд:	<p>Зам, тээврийн хөгжлийн яамны Автотээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Е.Жаргалсайхан;</p> <p>Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Л.Чой-Иш;</p> <p>Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дэд дарга Д.Энхсайхан;</p> <p>Тээврийн цагдаагийн албаны дарга Д.Амарсайхан;</p> <p>Нийтийн тээврийн үйлчилгээний газрын дарга Ч.Сайханбаяр;</p> <p>"Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ-ын захирал Б.Гүрсоронзон;</p> <p>"Улаанбаатар төмөр зам" ХНН-ийн орлогч дарга Г.Ганболд;</p> <p>Монголын автотээвэрчдийн нэгдсэн холбооны гүйцэтгэх захирал Д.Наранпүрэв.</p>
Нарийн бичгийн дарга	Зам, тээврийн хөгжлийн яамны Автотээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн С.Нансалмаа

Монгол Улсын Шадар сайдын
2020 оны 142 дугаар тушаалын
хөвдугаар хавсралт

Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн
үед хүнс болон нэн шаардлагатай бараа бүтээгдэхүүнийг
тээвэрлэх, түгээхэд баримтлах түр журам

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү түр журмын зорилго нь Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед хот дотор болон хот хооронд хүнс, нэн шаардлагатай өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний тээвэрлэлт, түгээлтийг тээврийн мэдээллийн удирдлагын нэгдсэн систем (цаашид "систем" гэх)-ээр дамжуулан зохион байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Эрх бүхий байгууллага (Улсын Онцгой комисс, Зам, тээврийн хөгжлийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам)-аас www.teeverzuuch.mn/-системд нэвтрэх эрх авч, бүртгүүлсэн ачаа илгээгч, тээвэрлэгч, ачаа хүлээн авагч нь хүнс болон нэн шаардлагатай бараа бүтээгдэхүүнийг тээвэрлэж, түгээнэ.

1.3. Ачаа илгээх, хүлээн авах, тээвэрлэхэд Улсын Онцгой комисс, эрүүл мэндийн болон холбогдох бусад байгууллагаас гаргасан дүрэм, журам, заавар, зөвлөмж, дэглэмийг мөрдөж ажиллана.

1.4. Энэхүү түр журмыг Монгол Улсын нутаг дэвсгэр дээр автотээврийн хэрэгслээр ачаа тээврийн үйлчилгээ эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллага, иргэн бүр дагаж мөрдөнө.

Хоёр. Ачаа илгээх, хүлээн авах

2.1. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч нь сум, дүүргийн хүнсний асуудал хариуцсан эрх бүхий этгээдэд хандан ачаа илгээх, хүлээн авах үйл ажиллагаа явуулах хүсэлтээ илэрхийлнэ.

2.2. Сум, дүүргийн хүнсний асуудал хариуцсан эрх бүхий этгээд нь орон нутагт шаардлагатай болон орон нутгаас тээвэрлэх хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн, нэн шаардлагатай бараа бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээ, ачаа илгээх, хүлээн авах хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн (Цаашид "үйлдвэрлэгч" гэх) талаарх мэдээллийг аймаг, нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт ирүүлнэ.

2.3. Аймаг, нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газар орон нутгаас ирүүлсэн мэдээг нэгтгэж, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлнэ.

2.4. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам хүнс, нэн шаардлагатай бараа бүтээгдэхүүн илгээх, хүлээн авах үйлдвэрлэгчийн жагсаалтыг гаргаж, Монголын автотээвэрчдийн нэгдсэн холбоо (цаашид "системийг хариуцагч байгууллага" гэх)-д хүргүүлнэ.

2.5. Системийг хариуцагч байгууллага нь жагсаалтад орсон үйлдвэрлэгчид системд нэвтрэх эрхийг олгоно.

2.6. Жагсаалтад орсон үйлдвэрлэгч нь www.teeverzuuch.mn системд нэвтэрч, ачаа, тээврийн захиалгыг оруулна.

2.7. Системээс өөрийн ачаанд үнийн санал өгсөн тээвэрлэгчдээс найдвартай тээвэрлэгчийг сонгож тээвэрлэлтээ гүйцэтгүүлнэ.

Гурав. Ачаа тээвэрлэх

3.1. Ачаа тээвэрлэлт гүйцэтгэх тээвэрлэгч нь тухайн орон нутгийн Засаг даргад хүсэлтээ гаргана.

3.2. Аймаг, нийслэлийн Засаг дарга хүсэлтийг нэгтгэн Зам, тээврийн хөгжлийн яаманд хүргүүлнэ.

3.3. Зам, тээврийн хөгжлийн яамнаас эрх бүхий тээвэрлэгчийн жагсаалтыг гаргаж, систем эзэмшигчид хүргүүлнэ.

3.4. Систем эзэмшигч нь түр журмын 3.3-т заасан жагсаалтад орсон тээврийн хэрэгсэл, жолоочид систем [/www.teeverzuuch.mn/](http://www.teeverzuuch.mn)-д нэвтрэх эрхийг олгоно.

3.5. Системд нэвтрэх эрх бүхий тээвэрлэгч нь оруулсан ачаанд тээвэрлэх санал, сонгогдсон тохиолдолд баталгаажуулан системээс QR код авч тээвэрлэлтийг эхлүүлнэ.

3.6. Тээвэрлэгч нь тээвэрлэлт гүйцэтгэхдээ системд маршрут, дамжин өнгөрөх цэгүүдээ нарийвчлан оруулж өгнө.

3.7. Тээвэрлэлтийн явцад хяналтын байгууллагын ажилтан зогсоох тохиолдолд тээвэрлэгч нь системээс өгсөн QR кодыг уншуулж шалгуулан тээвэрлэлт гүйцэтгэж байгаагаа баталгаажуулж, тээвэрлэлтээ үргэлжлүүлнэ.

Дөрөв. Ачаа тээвэрлэлтийг хянах


4.1. Хяналтын байгууллагын ажилтан гар утсандаа QR код уншигч суулгасан байна.

4.2. Хяналтын байгууллагын ажилтан тээвэрлэлт гүйцэтгэж байгаа тээвэрлэгчээс тээвэрлэлтийн QR кодыг шаардах бөгөөд уг QR кодыг уншуулж тээвэрлэлт болон маршрутын мэдээллийг авна.

4.3. Тээвэрлэлт болон маршрутын мэдээлэл үнэн зөв байвал тээвэрлэгчийг тээвэрлэлтээ үргэлжлүүлэхийг зөвшөөрч, харин мэдээлэл буруу байвал нэвтрүүлэхээс татгалзана.

4.4. Системийг хариуцагч байгууллага нь системийн үйл ажиллагаанд хяналт тавьж, найдвартай байдлыг хангана.

Тав. Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед хүнс болон нэн шаардлагатай бараа бүтээгдэхүүний тээвэрлэлт, түгээлтийн зохион байгуулалтын бүдүүвч зураг



Зургаа. Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үеийн хүнс тээвэрлэлтийн аюулгүй байдлын болон эрүүл ахуйн шаардлагууд

6.1. Улаанбаатар хот руу мал, мах тээвэрлэх тохиолдолд Эмээлт, Шар хөтөл, Өлзийт, Таван толгой, Хэрлэн зэрэг товчоогоор өглөөний 04:00-06:00 цагийн хооронд нэвтэрч, тухайн өдрийн 00:00 цагт багтаан ачаагаа авч Улаанбаатараас гарсан байх, заасан хугацаанд нэвтрээгүй бол маргааш өдрийн тухайн цагт нэвтрэх зохицуулалтыг Тээврийн удирдлагын нэгдсэн системд хийсэн байна.

6.2. Тээвэрлэгч нь хүнс тээвэрлэх хугацаанд хамгаалалтын хувцас, нүүрний хамгаалалт, бээлий, гар ариутгагч зэрэг хувийн хамгаалах хэрэгслийг эрүүл мэндийн байгууллагын зөвлөмжийн дагуу зөв хэрэглэнэ.

6.3. Тээвэрлэгч нь түр журмын 6.2-т заасан хамгаалах хэрэгслийн хангалттай нөөцийг бэлтгэн тээвэрлэлтийн туршид авч явна.

6.4. Хот суурин газрыг дайран өнгөрөхдөө аль болох зогсохгүй, шаардлагатай тохиолдолд түр зогсвол тээврийн хэрэгслээс буухгүй.

6.5. Тээвэр хийх явцад хот суурин газар нэвтрэх, дайран өнгөрөхдөө тухайн орон нутагт тогтоосон дүрэм, журам, шаардлагыг мөрдөнө.

6.6. Тээвэрлэлтийн туршид холбоо барих хэрэгслийг биедээ авч явна.

6.7. Хүнс тээвэрлэж буй тээврийн хэрэгсэл, чингэлгийг тухай бүр ариутган, эрүүл ахуй, халдвар хамгааллын шаардлагыг мөрдөнө.

6.8. Хүнсний тээврийн хэрэгсэлд зорчигч тээвэрлэхгүй.

6.9. Тээвэрлэлтийн үед түр зогсож буухдаа хүн, мал амьтан, эд зүйлстэй харьцахгүй, хүрэлцэхгүй, халдвар хамгааллын дэглэмийг чанд баримтлана.

6.10. Бараа бүтээгдэхүүнийг ачих, буулгах явцад хамгаалалтын хувцас хэрэгслийг бүрэн өмсөж, бусадтай зайнаас харьцана.

6.11. Хувийн ариутгал, халдваргүйтлийг тухай бүр хийж, хамгаалалтын хувцас, бээлий, амны хаалтыг тайлах болон хаяхдаа холбогдох заавар, зөвлөмжийг дагаж мөрдөнө.

6.12. Ачаа, барааг хүлээн авагчид хуваарийн дагуу нийлүүлсэн тухай мэдээллийг Тээврийн удирдлагын нэгдсэн систем /www.teeverzuuch.mn/-д цахимаар бүртгүүлнэ.

6.13. Тээврийн удирдлагын нэгдсэн системд бүртгэлийг хийгээгүй тохиолдолд дараагийн ачаа тээврийн захиалга хийгдэхгүй.

6.14. Ачаа, тээврийн төлбөр тооцоог цахим хэлбэрээр хийнэ.

6.15. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг тээвэрлэхээс өмнө шалгаж, хүлээн авна. Муудсан, бохирдсон хүнсийг ялгаж, зайлуулах ба тээвэрлэхгүй.

6.16. Хүнсийг хөргүүр бүхий зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ. Дулаан хэмжих термометрийг суурилуулсан байна.

6.17. Хөргөөсөн хүнсийг 5°C хэмээс доош, хөлдөөсөн хүнсийг -18°C хэмээс доош хэмд, хурааж, тээвэрлэнэ.

6.18. Өөр өөр төрлийн хүнсний бүтээгдэхүүнийг тусад нь хурааж, тээвэрлэнэ. Боловсруулсан бэлэн хүнсийг түүхий, болгоогүй хүнснээс ямагт тусад нь хурааж, тээвэрлэнэ.

6.19. Шууд хэрэглэх, нэг бүрээр нь савлаагүй, задгай хүнсийг тээврийн сав баглаа боодолд савлаж, нямбай, зөв хурааж, тээвэрлэнэ.

6.20. Хөлдөөсөн, хөргөөсөн хүнсийг хөргүүртэй тээврийн хэрэгслээр тээвэрлэж, температурын горимыг чанд баримтлана.

6.21. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг тээвэрлэхдээ хүлээн авагчтай урьдчилан цагаа тохирч, тохирсон хугацаанд шуурхай, цаг алдалгүй тээвэрлэнэ.

6.22. Хөлдүү хүнсний бүтээгдэхүүнийг хөргүүртэй тээврийн хэрэгслээс буулгасан даруйд шууд хөргүүртэй агуулахад хурааж, хадгална. Ямар ч тохиолдолд тасалгааны хэмтэй газар хадгалж болохгүй.

6.23. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн тээвэрлэдэг тээврийн хэрэгслээр өөр төрлийн бараа бүтээгдэхүүн тээвэрлэх зорилгоор ашиглахаас зайлсхийнэ. Тухайлбал, химийн бодис, хог гэх мэт.

6.24. Хүнс тээвэрлэх тээврийн хэрэгслийн ачааны бүхээгийг зориулалтын бодис, хэрэгслээр тогтмол цэвэрлэж, ариутгал хийнэ.

6.25. Цельсийн 5°C - 60°C хэм нь бүх төрлийн бичил биет өсч үржих, бохирдол үүсэх хамгийн таатай орчин "Аюултай бүс" тул хөргөөсөн, хөлдөөсөн хүнсийг тээвэрлэж болохгүй.

6.26. Хүнсний зориулалтын тээврийн хэрэгслийн жолооч нар хүнсний эрүүл ахуйн сургалтад шат дараалалтай хамрагдаж, эрүүл ахуйн зохистой дадал, дүрмийг баримталж ажиллана.

Долоо. Хариуцлага

7.1. Монгол Улсын Засгийн газар, Улсын Онцгой комисс, эрүүл мэндийн болон холбогдох бусад байгууллагаас гаргасан тогтоол, шийдвэр, дэглэм, зөвлөмжийг дагаж мөрдөөгүй ачаа илгээгч, тээвэрлэгчид холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын дагуу хариуцлага тооцно.